

“Бизнесийн орчны шинэтгэл ба татвар” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд зориулсан илтгэл

“Жижиг дунд бизнес эрхлэгчдийг татварын бодлогоор дэмжих нь”

- ❖ Жижиг дунд бизнес эрхлэгчдийн талаар төрөөс баримталж буй бодлого
- ❖ Жижиг дунд бизнес эрхлэгчдийн татвар төлж буй өнөөгийн байдал
- ❖ Жижиг дунд бизнес эрхлэгчдийг татварт бүрэн хамруулах асуудал
- ❖ Бизнес эрхлэгчдэд татвар төлөх үүргээ биелүүлэхэд нь туслах, татвар төлөгчдийн ухамсрыг дээшлүүлэх
- ❖ Олон улсын туршлага
- ❖ Дүгнэлт

Оршил

Төрөөс жижиг, дунд үйлдвэрийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээ, хамрах хүрээг тодорхойлон үндэсний эдийн засгийн хөгжлийг хангахад оршино.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай, Хоршооны тухай, Нөхөрлөлийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Жижиг дунд бизнес эрхлэгчид нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга байрлан үйл ажиллагаа эрхэлдэг дотоодын аж ахуйн нэгж, хувиараа аж ахуй эрхэлж буй Монгол Улсын иргэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугч гадаадын иргэн, харъяалалгүй хүн /цаашид "иргэн" гэх/-д байна.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч гэдэгт дараахь шаардлагыг хангасан, хуулийн дагуу бүртгүүлсэн аж ахуйн нэгж, иргэнийг ойлгоно.

- контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;

- контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 149-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;
- контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиглэнгийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;
- контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 49-өөс дээшгүй бөгөөд 1 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;
- контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 19-өөс дээшгүй бөгөөд үйлдвэрлэл эрхэлдэг, эсхүл контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 9-өөс дээшгүй бөгөөд худалдаа, үйлчилгээ эрхэлдэг, 250 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиг үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж нь компани, хоршоо, нөхөрлөл гэсэн хэлбэртэй байх бөгөөд хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар, хараат болон охин компанийн холбогдох үзүүлэлтийг оруулж тооцно.

Татварын бодлогын шинэчлэлийн гол зарчим нь албан татварын хувь хэмжээг зохистой нам түвшинд тогтоох, эдийн засгаа хамгаалах зорилгоор зарим төрлийн татвар, төлбөр /гаалийн албан татвар, онцгой албан татвар, нөөцийн төлбөр/-ийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, шинээр зарим төрлийн татвар /байгаль орчныг нөхөн сэргээх татвар, лицензийн татвар, өв залгамжлал, бэлэглэлийн татвар/-ыг хуульчлан батлах, татварын суурийг өргөтгөх замаар татвар төлөгчдийн ачааллыг бууруулах зэрэг цогцолбор арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд оршино.

Татварын шинэчлэл нь атварын тогтолцоог өөрчилж дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг тэгш, шударга зарчмаар дэмжихэд оршино. Нэмэлт хөрөнгө оруулалтын үр дүнд ажлын байр бий болж улмаар ядуурал буурах юм. Уг ажлын байрууд бодитоор бий болсноор татварын бааз суурь өөрөө

өргөжих талтайТатварын баазыг өргөтгөснөөр татварын хувь, хэмжээ бууруулах боломж бүрддэг.

Татварын суурь * Татварын хувь = Төсөвт орох татварын орлого

Төрийн үйлчилгээг ард түмэнд хүргэхийн тулд өрд тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгө шаардлагатай болдог. Одоогоор манай улсын хувьд атварын бааз сул байгаа бөгөөд жижиг дунд бизнес эрхлэгчдэд ажлын байр болон мөнгө санхүүгийн дэмжлэг /Жнь: Бага хүүтэй урт хугацааны зээл олгох/ үзүүлэх талаар дутмаг байгаа бөгөөд тэдэнд ногдуулах татварын хувь хэмжээг багасгах зэрэг нь төрөөс ард түмэнд үзүүлэх хамгийн чухал асуудал болж байна.

Эрдэмтэд, судлаачдын нэг хэсэг нь орлогын албан татварыг шатлалгүй нэг хувь хэмжээтэй болгох, мөн зарим хэсэг нь одоогийн шатлалыг нэмэгдүүлэх ёстой гэсэн янз бүрийн санал гаргаж байна.

Харин зарим нэг эрдэмтэд Монгол улсад одоохондоо шатлалгүй татварт шилжих цаг хугацаа хараахан болоогүй гэж үзэж байна. Учир нь Монгол улсад үндэсний гэхээр үйлдвэрлэл хөгжөөгүй, одоогийн үйлдвэрүүдийн ашиглаж буй техник, технологи нь орчин үеийн хэрэгцээ шаардлагаас хол хоцорсон, үйлдвэрлэлээс олж буй ашиг нь салбаруудын онцлогоос хамаарч эрс ялгаатай, ийм нөхцөлд орлогын албан татварыг нэг хувь хэмжээтэй болговол жижиг дунд үйлдвэрлэгчдийн татварын ачаалал нэмэгдэж, ингэснээр үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого алдагдахад хүрэхийг үгүйсгэх аргагүй. Жижгээс том руу шилждэг зарчим ёсоор үндэсний томоохон үйлдвэрлэгчдийг олон мянгаар нь бий болгохын тулд юуны өмнө жижиг дунд үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор дэмжиж, хөгжүүлэх нь юу юунаас чухал.Иймд одоогийн орлогын албан татварын шатлалыг үйлвэрлэгчдийн ашгийн түвшин жигдэртэл мөрдөх нь зөв гэж үзжээ.

Иймд дээрхи бүх санал бодлуудыг агуулсан татварын хуулиудын шинэчлэл хийх шаардлагатай байна.

Монгол Улсын татварын шинэчлэлийн нэг гол зорилго нь иргэдэд ажлын байр бий болгох явдал юм. Аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагаандаа нэмэлт хөрөнгө оруулснаар дээрх зорилт биелэх юм. Хэдийгээр орчин үеийн үйлдвэрлэлд хүний хүчин зүйлийг техник, технологи орлоно гэсэн болгоомжлол байдаг боловч хөрөнгө оруулалт ажлын байр шинээр бий болгодог гэж үзэж

болно. Хүний хүчин зүйлийг техник, технологитой хослуулснаар Монгол Улсын өрсөлдөх чадвар дотооддоо төдийгүй олон улсад дээшлэх боломж бүрдэнэ.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын хөрөнгө оруулалтыг дэмжих 2 нийтлэг арга байдаг. Эдгээр аргуудын эцсийн үр нөлөө нь адил юм. Үүний нэг нь хурдасгасан элэгдлийн арга буюу үндсэн хөрөнгийг богино хугацаанд элэгдүүлэх эсвэл уг хөрөнгийн ашиглалтын эхний жилүүдэд өндөр хувиар элэгдэл тооцох арга юм. Нөгөө арга нь хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт байдаг. Аж ахуйн нэгж, байгууллагууд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийгээд татварын хөнгөлөлт эдлэх юм.

"Монгол улсын эдийн засгийн чадавхийг бэхжүүлж, өрсөлдөх чадварыг хангахад чиглэгдсэн" татварын багц хуулийн шинэтгэл нь дараах зорилтуудад чиглэгдэж байна:

1. Шинэ ажлын байр бий болгож, бизнес эрхлэгчдэд ногдох татварын ачааллыг бууруулах замаар Монголын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
2. Цалин хөлсний татварын хэмжээг багасгаж, ажиллах хүчний зардлыг бууруулснаар ажиллах хүчинд ногдох татварын дарамтыг багасгах
3. Татварын албаны үйл ажиллагааг өнгөн шуурхай болгохүйлчилгээг татвар төлөгчдөд үзүүлэх чиглэлд түлхүү анхаарах
4. Татварын дарамтыг багасгаснаар далд эдийн засгийг бууруулж татварын баазыг нэмэгдүүлэх
5. Татварын ялгавартай байдлыг арилгаж, дотоод үйлдвэрлэгчдийг дэмжих
6. Татварын системийн зөв гольдролд орсноор хүчгийн найдвартай орчныг бий болгох

Дээрх зорилтуудыг хангахаар санал болгож буй татварын шинэтгэлийн багц нь доорхи онцлогуудыг агуулж байна:

- Татварын хөнгөлөлт нь шинээр ажлын байр бий болгох замыг компаниудын өмнө нээж өгснөөр улам олон Монголчууд эдийн засгийнхаа ирээдүйд оролцох боломжийг өргөжүүлэх
- Татварын шударга хувь хэмжээг тогтоосноор иргэдийн эдийн засгийн өсөлтөд идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлэх
- Ажиллах хүчинд ногдох татварын дарамтыг бууруулж тэдний бодит орлогыг нэмэгдүүлэх

- Өрсөлдөх чадварыг дэмжсэн татварын хөнгөлөлт нь ажил олгогч, ажиллах хүчинд ногдох татварын ачааллыг багасган, улмаар компаниудын шинэ бүтээл, өсөлтөд оруулах шаардлагатай хөрөнгө оруулалтын чухал эх үүсвэрийг чөлөөлж өгөх
- Эдийн засгийн чадавхийг бүхэлд нь бэхжүүлснээр иргэдийн орлого нэмэгдэн далд эдийн засаг буурч татварын бааз суурь нэмэгдэх бөгөөд шинээр ажлын байр бий болгох боломж бүрдэх.

Татварын алба, байцаагчдын зүгээс татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийн тулд хуулийн этгээдүүдийн төлөөлөл болон татвар төлөгч иргэдтэй харилцах зайлшгүй шаардлага гардаг. Эдгээр харилцаа төрийн хууль, тогтоомжуудын хүрээнд явагддаг. Монгол улсын хувьд шинэ цагийн татварын алба бий болсон 1990 оноос эхлэн “татвар төлөгч” гэсэн нэр томъёо бий болж, тэдгээрт үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэрүүд үүсчээ. Манай улс нь хуулийн дагуу татвар төлөгч өөрөө татварын ногдлоо тодорхойлж төлөх зарчимтай тул татварын албаны зүгээс тэдгээрт төрийн өмнөөс татвар төлөгчийн үүргээ биелүүлэхэд нь туслах, үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээдэг. Татварын албаны хувьд ажлын эцсийн үр дүн нь сайн дураараа татвар төлөх үүргээ биелүүлж, хуулийн дагуу өөрөө татвараа ногдуулж төлдөг татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлснээр тодорхойлогдох ёстой.

Монгол улсын Татварын алба өнгөрсөн 15 жилийн хугацаанд татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээний олон төрөл, хэлбэрүүдийг нэвтрүүлэн ажилласан байна.

Татвар төлөгчдийг шаардлагатай мэдээллээр хангах, татвар төлөгчдийн хуулиар хүлээсэн үүргийг нь ухамсарлуулах үйл ажиллагааг татварын алба, байцаагчдын зүгээс хөнгөн шуурхай, зөв боловсон хүргэх үйл ажиллагааг “Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ” гэж тодорхойлж болно.

Татвар төлөгчдөд үзүүлж байгаа үйлчилгээг үндсэн 2 төрөлд хувааж болохоор байна. **Үүнд:**

1. Татвар төлөгчдөд зориулсан сургалт, сурталчилгаа хийх
2. Татвар төлөгчдөд зөвлөгөө өгөх, туслах

Эдгээр үйл ажиллагааг дараахь арга замуудаар хэрэгжүүлж байна.

- A. Сургалт, сурталчилгаа хийх

- хуулийн этгээдийн удирдлага, нягтлан бодогчдод зориулсан сургалт
- олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан хийгдэх татварын сургалт, сурталчилгааны ажил /телевиз, радио, сонин, радио уэль ашиглан сургалт, сурталчилгаа хийх, цахим хуудсаар сургалт сурталчилгааны төрөл бүрийн мэдээлэл цацах гэх мэт/
- татвар төлөгчдөд зориулсан ном товхимол, хуулийн эмхэтгэл, зурагт хуудас, DVD, VCD, CD гаргах
- ирээдүйн татвар төлөгчдөд зориулсан сургалт, сурталчилгааны ажил

Б. Зөвлөгөө өгөх, туслах

- Татвар төлөгчдийн асуултанд хариулах үйлчилгээ /биечлэн, утсаар, цахим хуудсаар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр/
- Тайлан гаргахад зөвлөгөө өгөх, энгийн бүртгэлийн программ хангамжаар туслах, тайланг факсаар хүлээн авах үйлчилгээ
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр татвар төлөгчдөд заавар, зөвлөмж өгөх /телевиз, радио, сонин, радио уэль, цахим хуудас, гар утасны мессеж зэргийг ашиглан зааварчилга, танилцуулга, анхааруулга зарлалын чанартай мэдээлэл хийх/
- Цахим хуудас ашиглан татвар төлөгчдийн үйл ажиллагааг хөнгөвчлөх үйлчилгээнүүд /электрон тайлан, оноосон нэрийн сонголт хийх, НӨАТ төлөгчийн бүртгэлийн жагсаалт, хууль, заавар, журмууд болон бүх төрлийн тайлангийн маягтууд татаж авах гэх мэт/

Татвар төлөгчдөд үзүүлэх дээрхи төрлийн үйлчилгээнүүдийг татварын албад өөрсдийн нөхцөл боломж, орон нутгийн онцлогт тохируулан явуулж байна. Эдгээр үйлчилгээг татварын албаны 1500 орчим ажилтнууд өдөр тутмын үйл ажиллагаагаараа хангаж байдаг боловч бусад төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдүүд, иргэдтэй ч идэвхитэй хамтран ажиллаж байгаа билээ.

Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээний арга хэлбэрийг оновчтой шийдвэрлэхийн тулд Монголын татварын алба үүсэн бий болсон цагаасаа эхлэн бодлогын болон үйл ажиллагааны чиглэлтэй олон арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлж иржээ.

Эдгээр үйл ажиллагааг зөвхөн ганцхан жилийн дотор төгс хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд татварын албаны үйл ажиллагааны байнгын зорилт байх нь дамжиггүй юм.

Татварын алба, байцаагчдаас татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх ажилд олон саад бэрхшээл хүндрэлтэй асуудал тохиолдож байсан, одоо ч шийдвэрлэвэл зохих манай татварын албанаас хамаарах болон эс хамаарах олон асуудлууд байгааг хэлэхгүй өнгөрөх аргагүй юм.

Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг оновчтой зөв, хүндрэл бэрхшээл багатай явуулахад дараахь хүчин зүйлүүд шууд болон шууд бусаар нөлөөлнө гэж үзлээ. Үүнд:

1. Татвар төлөгчдийн татвар төлөх ухамсар өндөр, хуулийн мэдлэг сайн байх
2. Татварын хуулиуд, аргачлал заавар, журмууд нь энгийн, ойлгомжтой байх
3. Татварын албаны ажилтнууд нь хуулиа нарийн сайн мэддэг, татвар төлөгчидтэй харьцахдаа хүнд суртал гаргалгүй хөнгөн шуурхай ханддаг байх
4. Татварын албаны ажилтнуудын ажлын ачаалалыг жигд хуваарилсан байх
5. Татвар төлөгчдөд үйлчлэх өрөө тасалгаа, техник хэрэгслийн нөхцөл боломж сайтай байх
6. Иргэдийн шилжилт хөдөлгөөн, хаягын бүртгэл нэгдсэн сүлжээтэй байх
7. Татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх ажиллагаанд төрийн болон төрийн бус байгуулага, иргэдийн хүчийг ашигладаг байх.

Эдгээр хүчин зүйлүүд өнөөгийн манай нөхцөлд ямар түвшинд байгаа, цаашид сайжруулахын тулд юу хийх ёстой вэ? гэдэгт хариулахыг оролдъё.

1. Татвар төлөгчдийн ухамсар, татварын хуулийн боловсрол ихээхэн доогуур байгаа нь нууц биш юм. Татвар төлөх үүрэг ухамсарыг зөвхөн өнөөдөр татварын албатай харьцаж байгаа татвар төлөгчдийн хүрээнд бус нийт ард иргэдэд төлөвшүүлэх бодлого боловсруулан, сүүлийн үед ихээхэн яригдаж байгаа “бүх нийтийн татварын боловсрол”-ын системийг жинхэнэ утгаар нь бий болгох зорилт тавин ажиллах шаардлагатай байна. Энэхүү системийг хэрэгжүүлэхийн тулд хүүхдүүдийн цэцэрлэгийн наснаас нь эхлээд ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах анги, их, дээд сургууль, коллежийн сургалтын хичээлийн хөтөлбөрт татварын хичээлийг оруулах, татварын

хуулийн талаар иргэдийн дунд явуулах сургалтыг хүчтэй хийх, олон нийтийн дунд хуулийн мэдлэгийн талаар уралдаан тэмцээн зохиох зэргээр урамшууллын механизм ашиглах, зайны сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхэд татвар төлөгчдийн сургалтын материаллаг баазыг бий болгох, сургалтын технологийн шинэчлэлт хийх, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай юм.

2. Хууль, тогтоомжууд нь энгийн ойлгомжтой байна гэдэг нь бүтцийн хувьд тухайн орны татвар төлөгчдийн боловсрол, хэв заншил онцлогт зохицсон нийтэд ойлгомжтой хэл найруулгатай, элдэв маргаантай, зөрчилтэй заалт багатай байхыг хэлэх болов уу. Манай татварын багц хуулиудын хувьд зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн эхэн, туршлага багатай үед боловсруулснаас сүүлийн үед маргаантай асуудлууд ихээхэн гарах болсон, мөн нэмэлт өөрчлөлт их ордогоос хуулийн зарим заалтуудын хувьд энгийн хүнд ойлгоход хүндрэлтэй болсон нь харагддаг. Шинэчилсэн татварын хуулиуд маань татвар төлөгчдөд энгийн, ойлгомжтой болсон гэдэгт найдаж байна. Татварын хуулиудыг хэрэгжүүлэхийн тулд татварын албанаас гаргадаг аргачлал, заавар, журмуудыг нарийн сайн боловсруулах нь хуулийг хэрэгжүүлэхэд ихээхэн хялбар дөхөм болох болов уу.

Татварын зохицуулалтын үр дүнг ашиглахад хууль тогтоомжийг боловсронгуй болгосноор төдий бус хэрэгжүүлэх нэгдсэн арга зүй тогтоох, мөрдөж байгаа аргачлал журмыг хуульд орсон өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн баталж мөрдүүлэхтэй нягт холбоотой байдаг. Одоогоор татварын албаны хэмжээнд татвар төлөгчидтэй харилцах харьцааг зохицуулах зорилготой 109 журам, заавар, аргачлал мөрдөгдөж байна. Эдгээрээс татвар төлөгчдөд хүндрэл үүсгэж, чирэгдэл учруулж байгааг нь нь судалж, хүчингүй болгох, өөрчилж боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ талаар ажлын хэсэг гарган ажиллаж байна. Цаашдаа элдэв төрлийн журам, дүрмийг аль болох багасгаж, хуулийн заалтуудыг тайлбарласан оновчтой цөөн тооны аргачлал, заавар, журмыг боловсруулж, мөрдүүлэн, татвар төлөгч нарт аргачлал, заавар, журмын сурталчилгааг хуулийн сурталчилгаатай хамт хийж байх нь зүйтэй байна.

3. Татварын албаны ажилтнуудын мэргэжил, мэдлэгийн түвшин, харьцааны соёлын талаар хангалттай зүйл ярьж болох авч хамгийн гол нь ажилтнуудын хууль, тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх асуудал гэж үзэж

байна. Холбогдох хууль, тогтоомжуудынхаа талаар сайн мэдлэгтэй ажилтан татвар төлөгчдийг чирэгдүүлдэггүй, татварын албаны нэр хүндийг ч авч явдаг байна.

Өнөөгийн манай практикт татварын албаны хамгийн их хүч хөдөлмөр, сурталчилгаа, үйлчилгээ шаарддаг орлого бүхий иргэдтэй ажиллах ажиллагаанд хамгийн туршлага багатай, шинээр ажилд орсон байцаагч нар болон өөр мэргэжлийн хүнийг эхэлж ажиллуулдаг. Сүүлийн үед татварын улсын байцаагчдыг хүн амын, хураалтын, хяналтын гэсэн 3 зэрэглэлд ангилж, албан тушаал бууруулах, дэвшүүлэх маягаар ажилтнуудыг томилж байгаа буруу тогтолцоо татварын албанд үйлчилж байгааг зоригтой өөрчилж, боловсон хүчний нэгдсэн цэгтэй бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай болсон байна.

Татварын байцаагч нарын шаталсан сургалтын тогтолцоог илүү оновчтой хэлбэрээр боловсруулж, хэрэгжүүлэх, татварын ажилтнуудыг мэргэжлийн зэрэг цолтой болгох, ажилтнуудад зориулсан хууль эрх зүй, харьцааны соёл, гадаад хэл гэх мэт чиглэлээр төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулах нь татварын албаны хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд ач холбогдолтой байх болно гэж үзэж байна.

4. Ажилтнуудын ажлын ачаалал жигд бус байх нь татвар төлөгч бүрт хүрч үйлчлэхэд сөргөөр нөлөөлдөг. Манай улсын хувьд татварын албаны нэг ажилтанд ногдох татвар төлөгчдийн тоо харилцан адилгүй байна. Улсын хэмжээнд татварын албаны нэг ажилтанд хуулийн этгээд 40, татвар төлөгч иргэн /хөрөнгийн болон патент, аж ахуй эрхэлсний татвар төлж байгаа иргэн/ 237, нийт 277 татвар төлөгч ногдож байна.

Улаанбаатар хотын томоохон дүүргүүдийн хувьд татвар төлөгчдийн тоо харьцангуй олонтой, нэг цэгийн үйлчилгээнд шилжсэн ч татварын тайлан тушаах үеэр ажлын ачаалал хэт ихэсдэг, энэ нь эргээд татварын тайланг шалгаж хүлээн авах ажилд муугаар нөлөөлж байгаа нь ажиглагдаж байна. Сүүлийн үед татварын тайлан тушаах сүүлчийн өдөр тайлангаа тушаавал татварын алба тайланг шалгаж хүлээн авч чаддаггүй гэсэн буруу ойлголт татвар төлөгчдийн дунд гарч байгааг ч анхаарах хэрэгтэй болсон байна. Цаашдаа татварын байцаагч ажилтнуудыг багаар ажиллуулах системийг боловсруулах, байнгын болон ажлын ачаалал ихтэй үед хүч нэмэгдүүлэн ажиллуулах, өөр өөр чиг үүрэгтэй хэлтэс, тасаг, байцаагчдыг харилцан бие биенээ нөхөх, туслах зарчмаар ажиллуулдаг болох нь чухал юм.

5. Нэгэнт татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээний талаар ярьж байгаа учраас татвар төлөгчийг хүлээж авах өрөө тасалгаа, орчин нөхцөл байдлыг ч бодолцохгүй байхын аргагүй юм. Татвар төлөгчид тохилог уужим өрөө тасалгаа, боловсон, соёлтой ажилтнуудаар сэтгэл хангалуун үйлчлүүлэх нь цаашид татварын албанд хандах татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлэх, татварын алба руу чиглэх урсгал бий болгоход чухал ач холбогдолтой байх болно.

Сүүлийн жилүүдэд манай татварын албадын ихэнхи хувь нь өөрийн гэсэн албан конторын барилгатай болсон нь татварын албаны хөгжлийн томоохон дэвшил юм. Гэвч олонхи татварын албадад нэг хүнд ногдох талбайн хэмжээ бага, татвар төлөгчдийг хүлээн авах нөхцөл боломж муутай байгаа билээ.

Татварын албаны үйл ажиллагааг жинхэнэ утгаар нь үйлчилгээний байгууллага болгохын тулд татвар төлөгч машинаа тавих зогсоолтой, тусгай хүлээлгийн өрөө, сандал ширээ, телевизортэй байхаас л эхлэх нь зүйтэй юм шиг. Цаашид татвар төлөгчдийг угтан авч, уулзах байцаагчдын өрөө тасалгааг нь зааж өгдөг, хуулийн талаар мэдээлэл, зааварчилга өгдөг, утсаар хариулт өгдөг мэдээллийн ажилтныг ч татварын алба бүрт ажиллуулах хэрэгтэй юм. Эдгээр нь татварын орлого оруулахад ямарч хэрэггүй зүйл гэж зарим хүн хэлж болох боловч татварын албыг нээлттэй, төрийн үйлчилгээний байгууллага болгоход иймэрхүү үйлчилгээ ихээхэн нөлөө үзүүлэх болно гэдэгт итгэлтэй байна.

Манай улсын хувьд татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг сайжруулахад хөрөнгө мөнгөний хомсдолтой байдал ихээхэн саад болдог. Эдийн засаг хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага /OECD/-ын гишүүн хөгжингүй 31 орны дунд хийсэн судалгаагаар татварын албад нийт төсвийнхөө 5-25 хувь /дундажаар 10 хувь/-ийг татвар төлөгчдөд зориулсан үйлчилгээнд зарцуулдаг байна. Манай улсын хувьд татварын албаны нийт зардлын 2.6 орчим хувийг татвар төлөгчдөд зориулсан үйлчилгээнд зарцуулж байна.

6. Манай орны онцлогтой холбоотойгоор иргэдийн шилжилт хөдөлгөөн ихтэй байдгаас тухайн иргэн оршин суугаа газраасаа өөр газар бүртгэлтэй байх, хуучин газраасаа хасалт хийлгэсэн боловч шинэ газраа огт бүртгүүлээгүй байх, хоёр хаягаар давхар бүртгэлтэй байх зэрэг зөрчил маш их байдаг. Энэ нь засаг захиргааны анхан шатны нэгжүүд болох баг, хороодын иргэдийн бүртгэл судалгаа нэгдсэн сүлжээгүйгээс шалтгаалж байна. Шилжилт хөдөлгөөн, хаягын бүртгэлийн замбараагүй байдал нь татварын албаны ажилд ихээхэн хүндрэл үүсгэдэг. Одоогийн практикт татвар төлөгч иргэд 2 өөр татварын албанд

давхар бүртгэлтэй байх нь элбэг. Мөн татварын албадад бүртгэлтэй авто тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэдийн бүртгэл, судалгаа ч ихээхэн зөрчилтэй байгаа нь харагддаг.

Иргэдийн бүртгэл судалгаа улсын хэмжээнд нэгдсэн сүлжээтэй, тухайн иргэний хаягын бүртгэл, татвар төлөлтийн байдал зэрэг нь цахим системд орсон тохиолдолд татварын албад орлого бүхий иргэдийг судлан бүртгэх, тэдгээрт хүрч үйлчлэхэд ихээхэн дөхөмтэй байх болов уу.

7. Татварын алба маань төрийн санг бүрдүүлэгч гол байгууллагын нэг болохынхоо хувьд төрөөс иргэдэд үйлчлэх үйлчилгээний томоохон төлөөлөл болдог. Гэхдээ эмнэлэг, сургууль, нийгмийн халамж, үйлчилгээний чиглэлийн төрийн байгууллагуудтай харьцуулахад иргэдэд орлого, үйлчилгээ үзүүлдэггүй, харин орлогын тодорхой хэсгийг нь татвар нэрээр авах чиг үүрэгтэй байгууллага учраас иргэд аль болох зугтаах хандлагатай байдаг. Ийм учраас татварын байгууллагаас үзүүлэх төрийн үйлчилгээ ихээхэн хөрөнгө мөнгө, хүн хүч, эв дүй шаарддаг.

Дэлхийн хөгжингүй орнуудын туршлагаас харахад татвар төлөгчдөд туслах, зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий төрийн болон бусад байгууллагын хүчийг татварын албад ихээхэн ашигладаг байна. Манай орны хувьд аудитын болон хууль зүйн зөвлөгөө өгдөг байгууллагууд, ТИНЗ нийгэмлэг, олон улсын зарим төслийн байгууллагууд татвар төлөгчдөд татварын хуулийн талаар заавар зөвлөгөө өгөх, туслах, татварын сурталчилгаа хийх чиглэлээр ажиллаж байна. Сүүлийн үед татварын зөвлөх гэсэн мэргэжилтэй хүмүүс ч гарч ирж байна. Эдгээр нь ихэвчлэн хуулийн этгээдүүдэд хандсан үйлчилгээ явуулдаг.

Татварын албад маань иргэдэд хүрч ажиллахын тулд орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтарч ажиллах зайлшгүй шаардлагатай байдаг. Ялангуяа баг, хороодтой хамтран ажиллаж, тэдгээрийн хүчийг ашиглах нь чухал юм. Мөн боловсролын төв байгууллагуудтай хамтран бүх шатны суралцагчдын хичээлийн хөтөлбөрт “татварын хичээл”-ийг оруулах талаар идэвхитэй ажиллах шаардлагатай. Мөн татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх ажиллагаанд төрийн бус байгууллага, сайн дурын иргэд, урлаг соёлын алдартнуудыг татан оролцуулдаг туршлага дэлхийн улсуудад байдаг. Манай улсад эдгээр үйл ажиллагааг өөрийн онцлог, нөхцөл байдалдаа тохируулан хэрэгжүүлж байгаа татварын албад ч байгаа бөгөөд нийт татварын албаны хэмжээнд нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах үүрэг бидэнд ногдож байна.

Жижиг дунд бизнесийн хөгжилд эрх зүйн орчин бүрдүүлэхэд анхаарч байгаа улс бол ОХУ байна.

- Жижиг дунд бизнесийн этгээд гэж ОХУ-ын субъектууд, олон нийтийн болон шашны байгууллага, буяны болон бусад сангуудад оруулсан хувь хөрөнгө дүрмийн сангийнх нь 25-аас дээшгүй хувийг эзэлдэг, жижиг бизнесийн этгээд биш хуулийн нэг эсхүл хэд хэдэн этгээдээс оруусан хувь хөрөнгө дүрмийн сангийнх нь 25-аас дээшгүй хувийг эзэлдэг ашгийн төлөө ажилладаг байгууллагыг хэлнэ. Ингэхдээ тайлангийн хугацаанд ажиллагсдын тоо дараахаас хэтэрч үл болно.

- Аж үйлдвэр, барилга, тээврийн салбарт-100 хүн
- Хөдөө аж ахуй, шинжлэх ухаан-техникийн салбарт-60 хүн
- Жижиглэн худалдаа, ахуйн үйлчилгээний салбарт-30 хүн
- Бөөний худалдаа болон бусад салбарт-50 хүн
- Хуулийн этгээд байгуулалгүйгээр бизнес эрхэлж буй хувь этгээдийг мөн жижиг бизнесийн этгээдэд хамааруулдаг байна.

Жижиг бизнес эрхэлж буй этгээд нь Засгийн газраас баталсан маягтын дагуу өргөдөл гаргаж, зохих байгууллагад бүртгүүлэн холбогдох хуулийн статустай болно.

- Жижиг үйлдвэрүүд улсын статистикийн ба нягтлан бодох бүртгэлийн тайланг Засгийн газраас баталсан хялбаршуулсан процедур болон маягт, загварын дагуу гаргаж өгөх бөгөөд тэд нь гол төлөв татварын асуудлыг шийдвэрлүүлэхэд шаардлагатай мэдээллийг агуулсан байна.

- ОХУ-ын Засгийн газар холбооны жилийн төсвийг оруулахаас өмнө жижиг бизнесийг улсаас дэмжих хөтөлбөрийг ОХУ-ын Төрийн думд жил бүр оруулдаг бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг холбооны төсвийн зарлага талд тусгайлан тусгадаг ажээ.

- Жижиг бизнесийг дэмжих улсын болон орон нутгийн хөтөлбөрт олон улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө гаргах арга хэмжээ ордог. ОХУ-ын Засгийн газар нь Төрийн думд жил бүр жижиг бизнесийн байдал, хөгжлийн төлөв, түүнийг улсаас дэмжих арга хэмжээнүүдийн тухай илтгэл тавьж, жижиг бизнесийг улсаас дэмжихэд зориулан төсвөөс зарцуулсан хөрөнгийн тайланг гаргаж өгдөг юм байна.

ОХУ-д жижиг бизнесийг дэмжих Холбооны сан нь ашгийн төлөө бус хуулийн этгээд байна. Түүний зорилго нь жижиг бизнесийг дэмжин хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө, өмч хувьчлалын

орлого, өөрийн үйл ажиллагааны орлого, дотоод , гадаадын хувь болон хуулийн этгээдүүдээс өгсөн сайн дурын хандив , үнэт цаас гаргаж худалдсаны орлого зэргийг хуримтлуулах замаар санхүүжүүлэх явдал юм.

- Уг сан жижиг бизнесийг улсаас дэмжих зориулалтаар олгож байгаа гадаадын болон дотоодын зээлд баталгаа гаргах эрхтэй юм байна. Жижиг бизнесийг дэмжих Холбооны сангийн дүрмийг Засгийн газар батлахаар хуульд заасан байна.
- Жижиг бизнесийн этгээд үйлдвэрлэлийн үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг адил төрлийн үндсэн хөрөнгөнд тогтоосон нормоос 2 дахин илүүгээр байгуулж, зардалдаа шингээх эрхтэй байдаг байна.
- Жижиг бизнесийн этгээдүүдэд зориулсан татвар ногдуулалт, бүртгэл, тайлангийн хялбаршуулсан системийн тухай хууль
- Уг хялбаршуулсан системийг хэрэглэснээр ОХУ-ын хуулиудад тогтоосон холбооны, бүсийн болон орон нутгийн элдэв татвар, хураамжуудын оронд жижиг бизнесийн этгээдийн тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүнгээр нэгдсэн нэг татвар ногдуулж, хурааж болох юм байна.
- Гэхдээ уг системд шилжсэн хуулийн этгээдийн хувьд гаалийн хураамж, автотээврийн хэрэгсэл худалдаж авсны татвар, лицензийн төлбөр болон нийгмийн даатгалын хураамж төлөх хууль, журмууд урьдын адил үйлчилнэ.
- Уг хялбаршуулсан системд бүртгүүлсэн хэрэглэгч дансны давхар бичилт хийхгүй, дансны төлөвлөгөө, бүртгэлийн бодлого хийхгүй байх эрхтэй байна.

Европын Холбооны жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжиж байгаа байдал

- Ихэнхи орнуудад нарийн тодорхойлолт байхгүй байна. Ихэвчлэн ажиллагсдын тоо, эргэлтийн хөрөнгийн хэмжээгээр тодорхойлдог байна.
- Итали, Ирланд, Франц улсад хөрөнгийн хэмжээгээр;
- Дани, Франц, Герман, Грек, Ирландад жижиг үйлдвэрээр 50.0-аас доош ажиллагсадтай бизнес эрхлэгчдийг тодорхойлдог байна.

Европын Холбооны жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжиж байгаа байдал

Орон бүр өөрсдийн онцлогт тохирсон бодлого явуулж байгаа боловч дараах нийтлэг хандлагууд ажиглагдаж байна.

- Өрсөлдөөнийг дэмжиж, тэргүүний бизнес эрхлэгчдийг шалгаруулах;
- Хөрөнгийн зах зээлд оролцоход нь дэмжлэг үзүүлэх;

- НББ-ийн хөнгөлөлт үзүүлэх;
- Зээлийн хөнгөлөлтэй бодлого;
- Зарим төрлийн татварын хөнгөлөлт;
- Экспортын бүтээгдэхүүнд дэмжлэг үзүүлэх гэх мэт.

Дүгнэлт

Монгол улсын хувьд жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих талаар хууль эрх зүйн орчин бүрдэж эхэлж байна.

- Нэгдсэн нэр томъёотой болох /бичил, жижиг, жижиг дунд гэх мэтээр янз бүрээр ярьж бичиж байна/
- Татварын хууль нь бүх татвар төлөгчдөд тэгш үйлчлэх зарчимтай тул бизнес эрхлэгчдийг жижиг, том гэж ангилан тусгайлсан хөнгөлөлт үзүүлэх боломгүй байна.
- Манай улсын хувьд татварын хувь хэмжээ харьцангуй бага байгаа тул бизнес эрхлэгчдэд ихээхэн таатай орчин бүрдсэн гэж үзэж болно.
- Жижиг дунд бизнес эрхлэгчдээс авч буй албан татвар харьцангуй бага байгаа боловч элдэв төрлийн хураамж, төлбөрүүдийн дарамт их, төрийн албаны хүнд суртал ихээхэн газар авсан зэрэг нь жижиг дунд бизнес эрхлэгчдийг үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд ихээхэн саад болж байна.
- Төрөөс жижиг дунд бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжихийн зэрэгцээ далд эдийн засагтай тэмцэх, албан бус секторыг бууруулах талаар дорвитой арга хэмжээ авах
- Жижиг дунд бизнес эрхлэгчдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх талаар төрөөс олон нийтийг хамарсан тодорхой ажлуудыг зохион байгуулж хэвших
- Шилжилт хөдөлгөөн, хаягийн бүртгэлийн замбараагүй байдал нь иргэдийн бүртгэл, судалгаанд ихээхэн зөрчил үүсгэж байна. Улсын хэмжээнд хаягийн нэгдсэн сүлжээтэй, тухайн иргэний бүртгэл, татвар төлөлтийн байдал зэрэг нь цахим системд орсон тохиолдолд татварын албад бизнес эрхлэгч иргэдийг судлан бүртгэх, тэдгээрт хүрч үйлчлэхэд ихээхэн дөхөмтэй байх болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.
2. Иргэний хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
3. Компанийн тухай- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 34 дүгээрт нийтлэгдсэн.
4. Хоршооны тухай- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1998 оны 2 дугаарт нийтлэгдсэн.
5. Нөхөрлөлийн тухай- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1995 оны 8-9 дүгээрт нийтлэгдсэн.
6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2001 оны 19 дүгээрт нийтлэгдсэн.
7. Засгийн газрын тусгай сангийн тухай- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2006 оны 27 дугаарт нийтлэгдсэн.
8. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2003 оны 22 дугаарт нийтлэгдсэн.
9. ОХУ-д жижиг бизнесийг улсаас дэмжих тухай ОХУ-ын хууль / 1995 он /
10. Жижиг бизнесийн этгээдүүдэд зориулсан татвар ногдуулалт, бүртгэл, тайлангийн хялбаршуулсан системийн тухай ОХУ-ын хууль / 1995 он /
11. Зарим төрлийн үйл ажиллагааны тооцоот орлогод ногдуулах нэгдсэн татварын тухай ОХУ-ын хууль / 1998 он /

**Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн
хяналт шалгалтын тасгийн
татварын улсын байцаагч Ч.Нарантуяа**